

2022.06.28-ний өдрийн .... тоот

шийдвэрийн хавсралтаар батлав

## **БАЯЛАГ БҮТЭЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХОЛБООНЫ ДҮРЭМ**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **Нэгдүгээр зүйл: Ерөнхий зүйл**

1.1. Баялаг Бүтээгчдийг Дэмжих Холбоо /цаашид "Холбоо" гэх/ нь үүсгэн байгуулагчийн 2015 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн шийдвэрийн дагуу байгуулагдсан, Монгол орон даяар хэрэгжиж буй "Баялаг бүтээгчдийг дэмжинэ" үндэсний төсөл хөтөлбөрт үндэслэн төслийг санаачлагчийн санаачлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа явуулах ашгийн төлөө бус, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага / мэргэжлийн холбоо / мөн бөгөөд цаашид "Холбоо" гэнэ.

1.2. Холбоо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.3. Холбооны дүрэм нь тус байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн үндсэн баримт бичиг бөгөөд энэхүү дүрэмд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа явуулна.

1.4. Холбоо нь өөрийн туг, тэмдэг, бэлгэдэлтэй байна.

1.5. Холбоо нь өөрийн тамга, бичгийн хэвлэмэл хуудастай байна.

1.6. Холбоо нь банкинд харилцах данстай байна.

1.7. Холбоо өөрийн шагналтай байна. Шагнал урамшуулал олгох журмыг Удирдах зөвлөл тогтооно.

1.8. Холбооны албан ёсны нэр нь монголоор "Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо", товчилсноор "ББДХ", англи хэлээр "Small and Medium Enterprises" буюу товчилсноор "SMEs" байна.

1.9. Холбооны төв байгууллага нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байна.

1.10. Холбооны бүртгэгдсэн албан байршил, шуудангийн хаяг:

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 2-р хороо. Энх тайваны өргөн чөлөө. Гранд Плаза цогцолбор 905 тоот

Утас:+976 9904 4075.

Цахим шуудан: [info@bayalagbuteegch.mn](mailto:info@bayalagbuteegch.mn)

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХОЛБООНЫ ЗОРИЛГО, ЗАРЧИМ, ЭРХ ҮҮРЭГ

### **Хоёрдугаар зүйл. Холбооны зорилго, зарчим**

#### **2.1. Холбооны зорилго, зарчим**

2.1.1. Холбооны зорилго нь Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч / цаашид *Баялаг бүтээгч гэх* /-дийг дэмжих, бизнесийн таатай тогтвортой орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Үндэсний эдийн засаг, нийгмийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг сайжруулахад санал оруулах, Төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, хөгжүүлэх, Гишүүдийнхээ нийтлэг эрх, ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах, Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ, экспортын чадамжийг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлах, соён гэгээрүүлэх, Эх оронч худалдан авалтыг дэмжих, Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ болон үндэсний томоохон үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх, Хүнсний аюулгүй байдал, үйлдвэрлэл, төрийн үйлчилгээнд хяналт тавих, Байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх, Инноваци нэвтрүүлэх, Төрийн зарим чиг үүргийг хуулийн дагуу гэрээлэн Төрийн өмнөөс үзүүлэхэд оршино.

2.1.2. Холбоо нь үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэх, аливаа нам, улс төр, шашнаас ангид байж, үйл ажиллагаагаа хараат бусаар бие даан, нээлттэй ил тодоор явуулж, гишүүдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төлөөлөн илэрхийлэх зарчмыг баримтлана.

### **Гуравдугаар зүйл: Холбооны эрх, үүрэг**

#### **3.1. Холбооны эрх.**

3.1.1. Холбооны гишүүдийнхээ хууль ёсны эрх ашгийг Төр засгийн байгууллагуудад төлөөлөн хамгаалах, үндэсний эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал, дүгнэлт гаргах;

3.1.2. Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, худалдаа, Холбооны дотоод үйл ажиллагааг дэмжих зорилгоор Холбооны дэргэд төрөл бүрийн сан ажиллуулах, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, худалдааны болон олон улсын төсөл хөтөлбөр, Гарааны бизнес, старт-ап төсөл хэрэгжүүлэх;

3.1.3. Төрийн болон төрийн бус байгууллага, эдийн засаг, бизнесийг дэмжих байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт гаргах зорилгоор төрөлжсөн Мэргэжлийн зөвлөл байгуулах;

3.1.4. Эрх хэмжээнийхээ хүрээнд гадаад, дотоодын байгууллага иргэдтэй хэлцэл хийх, харилцаа тогтоох, гэрээ, хэлэлцээр, протокол, санамж бичиг байгуулж хэрэгжүүлэх;



3.1.5. Үндэсний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг дэмжин, бизнес эрхлэгчдэд гадаад орны түншүүдтэй ажил хэрэгч, хамтын ажиллагааны харилцаа холбоо тогтоох, дотоод гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг шударга тэнцвэртэй байлгахад дэмжлэг үзүүлэх;

3.1.6. Баялаг бүтээгчдийн бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагааг таниулан сурталчлах, борлуулалтыг нь өсгөн нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх зорилгоор гадаад дотоодын үзэсгэлэн яармаг, экспо зэрэг арга хэмжээ зохион байгуулах, хамтран оролцох;

3.1.7. Аж ахуй нэгж байгууллага, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, банк санхүү, төрийн эрх бүхий байгууллагуудын хүсэлтээр гишүүн байгууллагуудынхаа талаарх тодорхойлолтыг тэдгээрийн зөвшөөрлийн үндсэн дээр гаргаж өгөх, харин гишүүдийнхээ эрх ашиг, сонирхол, бизнесийн үйл ажиллагааны эсрэг тодорхойлолт гаргахгүй;

3.1.8. Салбар хорооны хүний нөөцийн бодлогыг сайжруулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, зорилгоор төрөл бүрийн сургалт, төсөл, хөтөлбөрт хамруулах, гишүүдийн дунд хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн сан байгуулж ажиллуулах;

3.1.9. Үндэсний үйлдвэрлэл үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаандаа онцгой амжилт гаргасан ахуйн нэгж, байгууллага, идэвхи зүтгэл гаргасан хувь хүнийг Холбооны шагналаар шагнаан урамшуулах, төр, засгийн одон медаль бусад шагналд тодорхойлох;

3.1.10. Дүрэмд заасан үйл ажиллагаа эрхэлдэг, адил төстэй үндэсний болон олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс гарах,

3.1.11. Баялаг бүтээгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага байгуулах,

3.1.12. Холбооны гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр Төрийн байгууллага, албан тушаалтанд хүсэлт, гомдол гаргах, арбитр болон шүүхэд нэхэмжлэл гаргах,

3.1.13. Олон улсын болон үндэсний арбитр, эвлэрүүлэн зуучлах төвийг байгуулах,

3.1.14. Хуулиар олгогдсон бусад эрх,

## **3.2. Холбооны үүрэг.**

3.2.1. Гишүүдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхол, бизнесийн үйл ажиллагааны эсрэг үйл ажиллагаа явуулахгүй байх,

3.2.2. Баялаг бүтээгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой хууль тогтоомжинд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг эрх бүхий байгууллагад гаргах, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцох,

3.2.3. Төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас эрх нь зөрчигдсөн Холбооны гишүүнд учирсан хохирлыг арилгахад туслах,

3.2.4. Гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсын үндэсний үйлдвэр, үйлчилгээний салбарт оруулах,

3.2.5. Байгаль орчинд ээлтэй үндэсний үйлдвэр, үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг эрэлхийлж, гишүүдэд санал болгох, Монгол Улсад эко бүтээгдэхүүний хөрөнгө



оруулалтыг олон улсын болон гадаад дотоодын байгууллагатай хамтын ажиллагааг дэмжих,

3.2.6. Мэргэжлийн ажилтан бэлтгэхэд бүх талын туслалцааг үзүүлэх, гишүүд болон мэргэжлийн боловсролын байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх,

3.2.7. Хуулиар олгогдсон бусад үүрэг.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГИШҮҮНЧЛЭЛ**

### **Дөрөвдүгээр зүйл. Холбооны гишүүнчлэл**

4.1. Холбоо нь гишүүнчлэлтэй байна.

4.1.1 Холбооны гишүүн нь энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрч сайн дурын үндсэн дээр элссэн, холбогдох хуулийн дагуу байгуулагдсан үндэсний үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага байна.

4.1.2. Гишүүний татвартай байна. Татвар хураамжийн хэмжээг Удирдах зөвлөл тогтооно.

4.1.3. Гишүүний татварыг хагас жил болон жилээр төлнө.

4.1.4. Холбоо нь Хүндэт Тэргүүн, Хүндэт гишүүнтэй байж болно.

4.1.5. Холбооны үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн буюу Холбооны эрх ашгийг тууштай хамгаалагч гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг Холбооны Тэргүүн санал болгосны дагуу Удирдах Зөвлөлийн хурлаар дэмжүүлэн, Ерөнхий зөвлөлийн олонхийн саналаар Хүндэт Тэргүүн, Хүндэт гишүүнээр батална. Хүндэт Тэргүүн, Хүндэт гишүүн татвар төлөхгүй.

4.1.7. Холбооны Хүндэт Тэргүүн, Хүндэт гишүүн Холбооны Их хуралд зөвлөх эрхтэйгээр оролцож болно.

4.1.8. Төрөлжсөн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага Холбоонд гишүүнээр элсэх хүсэлтийг бичгээр гаргана. Хүсэлтийг Удирдах Зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.1.9. Холбоо нь Дэмжигч гишүүнтэй байж болох бөгөөд Холбооны үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх иргэн, хуулийн этгээд байна. Дэмжигч гишүүн нь татвар төлөх үүргээс чөлөөлөгдөх ба харин хандив өргөж болно.

4.1.10. Холбооны төлөөлөл болж, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан Сан, Зээлийн батлан даалтын сан, Хоршоог хөгжүүлэх сан болон бусад сангийн төсөл сонгон шалгаруулах болон хяналт тавих хороо, зөвлөл, корпораци, хэсэгт ажиллах гишүүн Холбоонд татвар төлж, гэрээ байгуулснаар бүрэн эрх нь хэрэгжинэ. Татварын хувь хэмжээг Удирдах зөвлөл тогтооно.

**Тавдугаар зүйл: Гишүүний эрх, үүрэг**



5.1. Гишүүний эрх, үүрэг:

5.1.1. Холбооны удирдах байгууллагыг сонгох, сонгогдох эрхтэй;

5.1.2. Холбооны их хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар санал бодлоо илэрхийлэх эрхтэй.

5.1.3. Холбооны болон Салбар хороонд холбооны үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал, хүсэлт, гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй.

5.1.4. Гишүүн нь өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, бизнесийн чиглэл болон орон нутгийн харьяаллаар зөвлөл, дэд хороо, ажлын хэсэг зэрэгт сайн дурын үндсэн дээр оролцож, Холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх эрхтэй.

5.1.5. Холбоо болон Салбар хороогоор хөнгөлттэй нөхцлөөр үйлчлүүлэх эрхтэй.

5.1.6. Холбооны дэмжигч гишүүн нь сайн дурын үндсэн дээр хандив өргөж болох бөгөөд энэ тухай Холбоо нь тайландаа тусгана.

5.1.7. Холбооны болон Салбар хорооны үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, үйл ажиллагааг дэмжих үүрэгтэй.

5.1.8. Гишүүний татварыг тогтоосон журмын дагуу хугацаанд нь төлөх үүрэгтэй.

5.1.9. Монгол Улсын хууль, Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны дүрмийг чанд сахин биелүүлэх үүрэгтэй.

5.1.10. Шударга өрсөлдөөнийг эрхэмлэх, бизнесийн ёс зүйг чандлан сахих үүрэгтэй.

5.1.11. Гишүүн нь гишүүнчлэлээс өөрийн саналаар гарах эрхтэй.

5.1.12. Гишүүн гишүүнчлэлээс татгалзсан тухай өргөдлийг Холбоо болон Салбар хороо хүлээн авснаар шийдвэрлэгдсэнд тооцно. Чөлөөлөгдсөн гишүүний татварыг буцаан олгохгүй.

5.1.13. Нэг жил гишүүний татвараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төлөөгүй гишүүний гишүүнчлэлийн эрхийг Салбар хорооны тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар түдгэлзүүлж, уг шийдвэрт татварыг нөхөн төлөх хугацаа болон нөхцлийг тусгаж өгнө.

5.1.14. Гишүүний эрхийг түдгэлзүүлсэн зөрчил арилсан гэж үзвэл гишүүнчлэлийг дахин сэргээж болно.

5.1.15. Энэхүү дүрмийн 5.1.9, 5.1.10-д заасан үүргээ биелүүлээгүй гишүүнийг Холбооны удирдах зөвлөл болон Салбар хорооны тэргүүлэгчдийн хурлаас сануулах бөгөөд ийнхүү сануулснаас хойш 30 хоногийн хугацаанд үүргээ биелүүлээгүй бол гишүүнээс чөлөөлнө.

5.1.16. Холбооны эсрэг үйл ажиллагаа явуулах, нэр хүндэд халдах зэрэг нь гишүүнээс чөлөөлөх үндэслэл болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **Зургаадугаар зүйл. Холбооны удирдлага.**

6.1. Холбооны удирдах байгууллагын бүтэц нь дараах шатлал, ангилалтай байна.

6.1.1. Их хурал.

6.1.2. Ерөнхий зөвлөл.

6.1.3. Удирдах зөвлөл.



6.1.4. Хяналтын зөвлөл.

6.1.5. Салбар хороо.

### **Долдугаар зүйл. Холбооны Их хурал**

7.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Холбооны их хурал / цаашид "Их хурал" гэнэ / байна.

7.2. Их хурал нь зургаан жил тутамд хуралдана.

7.3. Их хурлыг Удирдах зөвлөл товлон зарлана.

7.4. Их хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Удирдах зөвлөл баталж, хурал эхлэхээс 14 хоногийн өмнө холбооны нийт гишүүдэд албан ёсоор мэдэгдэнэ. Их хурлын талаарх албан ёсны мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэнэ.

7.5. Удирдах зөвлөлөөс тухайн Салбар хорооны гишүүнчлэлийн тоо, ажлын үр дүнг нь харгалзан шууд квот тогтоож өгсөн шийдвэрийн дагуу Салбар хороод Их хурлын төлөөлөгчдөө сонгоно. Салбар хороодоос сонгох төлөөлөгчийн тоо харилцан адилгүй байж болно.

7.6. Сонгогдсон төлөөлөгч Их хуралд өөрийн биеэр оролцоно.

7.7. Холбооны дүрмийн 5-р зүйлийн 5.1.7-5.1.10-д заасан үүргийн биелэлт нь Их хуралд төлөөлөгчөөр сонгогдох эсэх үндэслэл болно.

7.8. Холбооны их хурал нь сонгогдсон төлөөлөгчдийн 50 хувь +1 ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцогдох ба асуудлыг ил санал хураах журмаар ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

7.9. Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн шийдвэрээр Ээлжит бус их хурлыг зарлан хуралдуулж болно.

7.10. Их хурлыг цахимаар хуралдуулж болох бөгөөд цахим хуралд оролцох төлөөлөгч, хуралдааны дэг журмыг Удирдах зөвлөл батална.

7.11. Их хурлаас тогтоол гарах бөгөөд даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

7.12. Их хурлын тогтоол гармагц хүчин төгөлдөр болно.

### **Найм. Холбооны их хурлын эрх, үүрэг.**

8.1. Их хурал дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

8.1.1. Холбооны үйл ажиллагааны талаар Холбооны Тэргүүний илтгэл.

8.1.2. Удирдах зөвлөлийн тайлан.

8.1.3. Холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгын төслийг батлах,


8.1.4. Холбооны Тэргүүн бөгөөд Удирдах зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх

8.1.5. Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх

8.1.6. Холбооны ирэх зургаан жилийн зорилт төлөвлөгөө.

8.1.7. Бусад асуудал.

### **Есдүгээр зүйл. Ерөнхий зөвлөлийн эрх, үүрэг**



- 9.1. Холбооны үйл ажиллагаанд туслах, зөвлөх зорилгоор Ерөнхий зөвлөлийг байгуулна.
- 9.2. Ерөнхий зөвлөлд Удирдах зөвлөлийн гишүүд, Холбооны дэд тэргүүн, Тэргүүний зөвлөхүүд, Салбар хорооны дарга нар байна.
- 9.3. Ерөнхий зөвлөл жилд нэгээс доошгүй удаа хуралдаж болно.
- 9.4. Ерөнхий зөвлөлийн хурлыг цахимаар хуралдуулж болох бөгөөд цахим хуралдааны дэг журмыг Удирдах зөвлөл батална.
- 9.5. Ерөнхий зөвлөлийн гишүүд нь сайн дурын үндсэн дээр ажиллах бөгөөд Ерөнхий зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2-оос дээшгүй удаа ирээгүй тохиолдолд тухайн албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.
- 9.6. Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж болно.
- 9.6.1. Ерөнхий зөвлөл нь Их хурлаас баталсан дүрмийн 30 хүртэлх хувийг өөрчлөх саналыг Удирдах зөвлөлд гаргаж болох бөгөөд уг санал эрхэм зорилго, үнэт зүйлсийг өөрчлөхгүй байна.
- 9.6.2. Холбооны цаашид хийх төлөвлөгөө, үйл ажиллагаатай холбогдуулан санал, зөвлөмж гаргах,
- 9.6.3. Холбооны хүндэт Тэргүүн, Хүндэт гишүүнийг батламжлах,
- 9.6.4. Холбооны жилийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болон өнгөрсөн жилийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх,
- 9.6.5. Холбооны их хурлын чөлөөт цагт Тэргүүний орон тоо гарвал** Удирдах зөвлөлд санал гаргах,

#### **Аравдугаар зүйл: Удирдах зөвлөл**

- 10.1. Удирдах зөвлөл нь Холбооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 10.2. Удирдах зөвлөлийн гишүүнийг Холбооны Тэргүүн нь Их хуралд танилцуулснаар зургаан жилийн хугацаагаар томилно.
- 10.3. Удирдах зөвлөл нь есөн гишүүнтэй байна.
- 10.4. Тэргүүн нь Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилохдоо холбооны үйл ажиллагаа, бодлогын залгамж чанарыг хадгалах үүднээс өмнөх Удирдах зөвлөлийн гишүүнийг улираан томилж болно.
- 10.5. Удирдах зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор аль нэг гишүүн нь чөлөөлөгдсөн, чөлөөлсөн тохиолдолд шинэ гишүүнийг Тэргүүн нь Удирдах зөвлөлийн хуралд танилцуулснаар бүрэн эрх хэрэгжинэ.
- 10.6. Удирдах зөвлөлийн хурлын зарыг тав хоногийн өмнө бүх гишүүдэд хүргэнэ.
- 10.7. Хурлаар хэлэлцэх асуудлыг гишүүдэд урьдчилан хүргүүлэх ба гишүүдийн олонхи шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн гишүүний санал болгосон асуудлыг хэлэлцэж болно.
- 10.8. Удирдах зөвлөлийн гишүүдийн 50%+1 хуралд ирснээр хүчинтэй бөгөөд асуудлыг ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 10.9. Удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гарах бөгөөд бичгээр гаргаж, Тэргүүн гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 10.10. Удирдах зөвлөлийн хурлыг цахимаар хуралдуулж болно.



- 10.11. Удирдах зөвлөлийн бүрэн эрх.
- 10.11.1. Холбооны Гүйцэтгэх удирдлагын ажлын албаны орон тоо, төсөв үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах,
- 10.11.2. Холбооны ээлжит болон ээлжит бус их хурлын товыг тогтоох,
- 10.11.3. Холбооны дүрэмд оруулах шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, Их хуралд санал гаргах,
- 10.11.4. Их хурлаас баталсан дүрмийн 30 хүртэлх хувийг өөрчилж болох ба эрхэм зорилго, үнэт зүйлсийг өөрчлөхгүй.
- 10.11.5. Удирдах зөвлөлийн хурлын журмыг батлах,
- 10.11.6. Холбооны хүндэт Тэргүүн, Хүндэт гишүүнийг сонгох саналаа Ерөнхий зөвлөлд оруулах,
- 10.11.7. Холбооны жилийн төлөвлөгөөг батлах,
- 10.11.8. Холбооны жилийн тайлан болон санхүүгийн гүйцэтгэлийг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх,
- 10.11.9. Холбооны шагналын журам батлах,
- 10.11.10. Холбооны Тэргүүний санал болгосноор Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, огцруулах,
- 10.11.11. Холбооны гүйцэтгэх удирдлагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн сан, үйлчилгээний үнэ тарифын талаар хэлэлцэх,
- 10.11.12. Татвар тогтоох,
- 10.11.13. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах,
- 10.11.14. Салбар хорооны үйл ажиллагааны нийтлэг журмыг батлах,
- 10.11.15. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан Сан, Зээлийн батлан даалтын сан, Хоршоог хөгжүүлэх сан болон бусад Сангийн төсөл сонгон шалгаруулах болон хяналт тавих хороо, зөвлөл, корпорац, хэсэгт ажиллах Холбооны гишүүний ажиллах журмыг батлах,
- 10.11.16. Холбооны их хурлын чөлөөт цагт Тэргүүний орон тоо гарвал Ерөнхий зөвлөлийн санал болгосноор батлах,
- 10.11.17. Холбогдох асуудлаар ажлын хэсэг байгуулах,
- 10.11.18. Хуулиар олгогдсон бусад эрх
- 10.12. Удирдах зөвлөлийн гишүүн татвартай байх бөгөөд татварын хэмжээг жил бүр Удирдах зөвлөлийн хурлаас тогтооно.

**Арваннэгдүгээр зүйл. Холбооны Тэргүүн буюу Удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг**

- 11.1. Холбооны Тэргүүн / цаашид "Тэргүүн" гэх / нь Удирдах зөвлөлийн дарга байна.
- 11.2. Тэргүүн нь зургаан жилийн хугацаатай Их хурлаас сонгогдох ба улиран сонгогдож болно.
- 11.3. Тэргүүн нь дараах бүрэн эрхтэй.
- 11.3.1. Холбоог гадаад дотоодод төлөөлөх, хамтын ажиллагааг идэвхижүүлэх;
- 11.3.2. Дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах;
- 11.3.3. Удирдах зөвлөлийн гишүүдийг томилох,



- 11.3.4. Холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх;  
11.3.5. Гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах, удирдамж, чиглэл өгөх,  
11.3.6. УИХ, Засгийн газар, Төрийн болон төрийн бус байгууллагуудтай Холбооны гишүүдийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах асуудлаар хамтарч ажиллах,  
11.3.7. Удирдах зөвлөлийн болон Ерөнхий зөвлөлийн хурлыг даргалах.  
11.3.8. Салбар, бодлого хариуцсан дэд тэргүүн, Ахлах зөвлөх, зөвлөхтэй байж болох бөгөөд ажил үүргийн хуваарийг тогтоох ба эдгээр албан тушаалтнууд ажлаа Тэргүүнд тайлагнана. Эдгээр албан тушаалтнууд сайн дурын үндсэн дээр ажиллана.  
11.3.9. Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчидтэй уулзалт хийж, саналаа Удирдах зөвлөлд оруулах,  
11.3.10. Аймаг, дүүргийн салбар хорооны даргыг томилох, чөлөөлөх, огцруулах,  
11.3.11. Хуулиар олгогдсон бусад эрх:

11.4. Дэд тэргүүн, Ахлах зөвлөх, зөвлөх нь нэг жилийн хугацаатай томилогдох ба дахин томилогдож болно.

11.5. Их хурлаас Холбооны Тэргүүнийг батламжилснаар өмнөх Тэргүүний бүрэн эрх дуусгавар болно.

#### **Арван хоёрдугаар зүйл: Удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүрэг.**

12.1. Удирдах зөвлөлийн гишүүн дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

12.1.1. Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг оруулах, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих,

12.1.2. Орон нутгийн салбар хороог хариуцах, удирдаж ажиллах,

12.1.3. Гүйцэтгэх захиралд нэрээ дэвшүүлж болох бөгөөд Гүйцэтгэх захирлаар томилогдсон тохиолдолд УЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөж болно.

12.1.4. Гүйцэтгэх захирлаас чөлөөлөгдсөн тохиолдолд өөрөө хүсэлт гаргавал УЗ-ийн гишүүнээр олонхийн саналаар эргүүлэн сонгож болно.

12.1.5. Холбооноос зохион байгуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх, хандив өргөх, босгох,

12.1.6. Дүрэм, журамд өөрчлөлт оруулах санал гаргах,

12.2. Удирдах зөвлөлийн гишүүнийг дараахь тохиолдолд Удирдах зөвлөлийн хуралд оруулж, олонхийн саналаар чөлөөлнө.


12.2.1. Өөрөө хүсэлт гаргасан

12.2.2. Удирдах зөвлөлийн гишүүний татвараа 1 жил төлөөгүй,

12.2.3. Удирдах зөвлөлийн хурлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа таслах,

12.2.4. Холбооноос зохион байгуулж буй арга хэмжээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2-оос дээш удаа оролцоогүй,

#### **Арван гуравдугаар зүйл. Гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг**



- 13.1. Холбооны гүйцэтгэх удирдлага нь Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд өдөр тутмын байнгын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 13.2. Гүйцэтгэх удирдлага нь Ажлын албатай байх бөгөөд Монгол Улсын хууль, дүрмийг баримтлан ажиллана.
- 13.3. Гүйцэтгэх захирал нь Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг чадварлаг, үр дүнтэй удирдан зохион байгуулах талаар Тэргүүнтэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.
- 13.4. Холбооны бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн сан, үйлчилгээний үнэ тарифын талаар Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 13.5. Холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Удирдах зөвлөлд оруулан хэлэлцүүлэх, үүнтэй холбогдон Удирдах зөвлөлөөс өгсөн чиглэл, даалгаврыг биелүүлэх төлөвлөгөө гарган, Удирдах зөвлөлийн даргаар батлуулан хэрэгжүүлнэ.
- 13.6. Олгогдсон эрх хэмжээний хүрээнд тушаал шийдвэр гаргана.
- 13.7. Холбооны салбар хороодыг нэгдсэн удирдлагаар хангана.
- 13.8. Тэргүүнтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Холбооны өмч хөрөнгийг захиран зарцуулна.
- 13.9. Удирдах зөвлөлд бодлогын чанартай санал хүсэлт тавих, хэрэгжүүлэх, мэдээллээр хангана.
- 13.10. Гүйцэтгэх захирлын бүрэн эрх нь дараагийн гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөл томилсноор дуусгавар болно.

**Арван дөрөвдүгээр зүйл: Аймаг, Нийслэл, дүүрэг, сумын салбар хороо.**

- 14.1. Холбоо нь орон нутагт салбар хороотой байна.
- 14.2. Салбар хороо нь Холбооны үндсэн чиг үүргийг тухайн орон нутагт гүйцэтгэх албан ёсны байгууллага мөн.
- 14.3. Аймаг, Нийслэлийн салбар хорооны даргыг Холбооны Тэргүүн, дүүрэг, сумын салбар хорооны даргыг Аймаг, Нийслэлийн салбар хорооны дарга тус тус томилж, чөлөөлнө.
- 14.4. "Салбар хорооны үйл ажиллагааны нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллана.
- 14.5. Салбар Хороо нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүр гарган Холбоонд ирүүлэх бөгөөд тайлангаа ирүүлээгүй бол Салбар хорооны даргыг чөлөөлөх үндэслэл болно.
- 14.6. Салбар хорооны дарга татвартай байх бөгөөд татварын хэмжээг жил бүр Удирдах зөвлөл тогтооно.

**Арван тавдугаар зүйл: Холбооны Хяналтын зөвлөлийн эрх, үүрэг**

- 15.1. Хяналтын зөвлөл 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Холбооны Их хурлаас зургаан жилийн хугацаатайгаар сонгогдох бөгөөд Их хурлын төлөөлөгчдөөс нэр дэвшүүлж, илээр санал хураана.
- 15.2. Хяналтын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдвөл Их хуралд санал хураасан нэрсийн жагсаалтын дагуу нөхөн сонгогдоно.

15.3. Хяналтын зөвлөлийн даргыг хяналтын зөвлөлийн гишүүдээс илээр санал хурааж, олонхийн саналаар сонгоно.

15.4. Хяналтын зөвлөл нь дүрмийн дагуу Удирдах зөвлөл болон ажлын алба, салбар хорооны үйл ажиллагаа, гаргасан шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтэд жилд нэгээс доошгүй удаа шалгалт хийж, дүгнэлт гаргана.

15.5. Гадаад аудитын байгууллагыг сонгох явцад хяналт тавьж, гадаад аудитын үйл ажиллагаа, тэдгээрээс Холбооны удирдлагад өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтийг хянана.

15.6. Холбооны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, хянана.

15.7. Холбооны удирдлагын дотоод хяналтын талаар гаргасан журам, дотоод хяналтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, холбогдох арга хэмжээ авахыг Холбооны удирдлагад санал болгоно.

15.8. Хяналтын зөвлөлийн дарга нь Удирдах Зөвлөлийн хуралд саналын эрхгүйгээр оролцож болно.

### **ТАВДУГААР БҮЛЭГ.БУСАД ЗҮЙЛ**

#### **Арван зургаадугаар зүйл: Холбооны өмч хөрөнгө**

16.1. Холбооны өмч хөрөнгө нь гишүүдийн татвар,гадаад, дотор байгууллагуудын хандив,зээл,тусламж,Монгол Улсын болон гадаад орнуудын Засгийн газар,олон улсын байгууллагаас бэлэглэсэн эд хөрөнгө,сан,өөрийн үйл ажиллагаанаас олсон оролого,тэдгээртэй адилтгах хөрөнгөөс бүрдэнэ.

16.2. Холбоо нь Монгол Улсын хууль,тогтоомжийн хүрээнд үйлчилгээ үзүүлж, өөрийгөө санхүүжүүлнэ.

16.3. Холбооны өмч хөрөнгө халдашгүй байна.

#### **Арван долдугаар зүйл: Холбооноос төр,засгийн болон бусад байгууллагатай харилцах**

17.1. Монгол Улсын хуульд зааснаас бусад тохиолдолд Төр,засгийн байгууллагаас Холбооны үйл ажиллагаанд, Холбооноос төр,засгийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй.

17.2. Холбоо нь Төр,засгийн баримталж байгаа эдийн засаг,нийгмийн бодлогыг дэмжин дэлгэрүүлэх,гадаад,дотоодод тайлбарлан таниулах,хэрэгжүүлэхэд туслах,тодорхой асуудлаар Холбооны гишүүд,баялаг бүтээгчид,үндэсний үйлдвэрлэгчдийн нийтлэг эрх ашиг,сонирхлыг илэрхийлэн хамгаалах үүднээс төр,засгийн байгууллагатай зөвшилцөх,хэлэлцээ хийх,шаардлага тавих,мэдэгдэл гаргах,санал зөвлөмж хүргүүлэх зэргээр хамтран ажиллана.

17.3. Холбоо нь хууль тогтоомжийн хүрээнд УИХ,Засгийн газрын холбогдох комисс,зөвлөл,хороо болон ажлын хэсэгт орж ажиллах, Яам, сайд, агентлагийн



даргын зөвлөл, аймаг орон нутгийн ИТХ, Засаг даргын байгуулсан бизнес,эдийн засаг,хувийн хэвшлийн үйл ажиллагаатай холбоотой орон тооны болоод орон тооны бус хороо,зөвлөл,ажлын хэсэг, Сангуудад төлөөллөө оруулан ажиллуулна.

17.4. Холбоо нь бусад төрийн бус байгууллага,мэргэжлийн холбоодтой харилцахдаа хууль дээдлэх, харилцан хүндэтгэх, дэмжин туслах, шударга байх, хамтран ажиллах зарчим баримтална.

17.5. Холбоо нь өөрийн болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан үйл ажиллагаагаа гишүүд, Баялаг бүтээгчид, үндэсний үйлдвэрлэгчид,олон нийт, төр засагт хүргэнэ.

**Арван наймдугаар зүйл: Холбоог татан буулгах,  
өөрчлөн зохион байгуулах**

18.1. Холбооны үйл ажиллагааг зогсоож,татан буулгах асуудлыг Их хурлын нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүй саналаар шийдвэрлэнэ.

18.2. Их хурлын шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр гармагц хүчин төгөлдөр болно.

**Арван есдүгээр зүйл: Дүрэм хүчин төгөлдөр болох**

19.1. Энэхүү дүрэм нь Холбооны хоёрдугаар их хурлаар батлагдсанаар хүчин төгөлдөр болох бөгөөд Улсын бүртгэлд бүртгүүлнэ.

ХОЛБООНЫ ТЭРГҮҮН

УЛААНБААТАР ХОТ



/ Ч.ДАВААБАЯР /

2022.06.28

